

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаяг
эсхүл дээрх QR кодыг ашиглан бусад
танилцуулга, мэдээтэй танилцана уу.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ3-4

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ..... 5

- 1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн: 5
- 1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ: 10

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ 11

- 2.1. Нэгдсэн төсвийн орлого: 11
- 2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага: 15

ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР..... 16

ДӨРӨВ. ГАДААД ХУДАЛДАА 17

- 4.1. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд: 17
- 4.2. Экспорт: 20
- 4.3. Импорт: 24

ТАВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ 26

- 5.1. Мөнгөний нийлүүлэлт: 26
- 5.2. Гадаад валютын албан нөөц: 28
- 5.3. Төлбөрийн тэнцэл: 29

ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 30

- 6.1. Хүн ам, ажил эрхлэлт: 30
- 6.2. Ажилгүйдэл: 31

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ



Эдийн засаг 2.4 хувиар өсжээ. 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 19.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.2 хувь буюу 2.5 их наяд төгрөгөөр, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ-ий хэмжээ 6.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.4 хувь буюу 143.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарсан байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 6,149.7 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 6,502.7 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 353.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Төсвийн орлогын хувьд: Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 6,149.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1,172.2 тэрбум төгрөгөөр буурч, тайлант хугацааны орлогын төлөвлөгөөний биелэлт 91.5 хувьтай байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 6,502.7 тэрбум төгрөгт хүрч, 68.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 807.3 тэрбум төгрөгөөр буюу 14.2 хувиар нэмэгдсэн байна.

Засгийн газрын нэрлэсэн өр: Засгийн газрын нэрлэсэн өрийн хэмжээ 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 34,616.3 тэрбум төгрөг байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4,849.1 тэрбум төгрөгөөр буюу 16.3 хувиар өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарлаа. 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 5,561.6 сая ам.доллар, экспортын худалдаа 3,013.0 сая ам.доллар, импортын худалдаа 2,548.6 сая ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 464.3 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Мөнгөний нийлүүлэлт өслөө. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар мөнгөний нийлүүлэлт 41,483.4 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 4,084.9 тэрбум төгрөг буюу 10.9 хувиар өссөн байна. Өнгөрсөн оны мөн үеэс мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд төгрөгийн хадгаламж 3,992.1 тэрбум төгрөг буюу 22.0 хувь, валютын хадгаламж 466.6 тэрбум төгрөг буюу 10.4 хувь, төгрөгийн харьцах 260.0 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 3 сард улсын хэмжээнд 9.1 хувь гарч, өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар өссөн байна.

Төлбөрийн тэнцэл алдагдалтай гарлаа. 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 991.6 сая ам.долларын алдагдалтай, харин санхүүгийн тэнцэл 821.2 сая ам.долларын ашигтай, хөрөнгийн тэнцэл 613.9 сая ам.долларын алдагдалтай тус тус гарсан байна.

Гадаад валютын нөөц өслөө. Нийт албан нөөцийн хэмжээ 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 4,996.0 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 146.9 сая ам.доллар буюу 3.0 хувиар өссөн байна.

Валютын ханш: Өмнөх оны мөн үеэс төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханш 2025 оны 3 дугаар сард 3,475.4 төгрөг болж 2.9 хувиар, төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 479.6 төгрөг болж, 2.3 хувиар мөн суларсан байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл: 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр хугацаа хэтэрсэн зээл 1,540.0 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 280.7 тэрбум төгрөг буюу 22.3 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.0 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурсан байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ: 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр чанаргүй зээлийн хэмжээ 2,048.7 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 9.5 тэрбум төгрөг буюу 0.5 хувиар буурч, чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.3 хувийг эзэлж байна.

Үнэт цаас: 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр үнэт цаасны арилжаагаар 172.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 268.5 сая ширхэг үнэт цаас арилжаалжээ. Өнгөрсөн оны мөн үеэс үнэт цаасны арилжааны гүйлгээ 15.5 тэрбум төгрөгөөр, арилжаалсан үнэт цаас 290.4 сая ширхгээр тус тус буурсан байна.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**


НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ**1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:****Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ:**

2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр бодит ДНБ-ий хэмжээ 2015 оны зэрэгцүүлэх үнээр 6.2 их наяд төгрөг болж, 2.4 хувьд хүрсэн байна.

2021 оны 1 дүгээр улиралд ДНБ-ий бодит өсөлт 14.8 хувьд хүрч уналтын дараах сэргэлт (V хэлбэрийн сэргэлт) гарсан хэдий боловч энэхүү өсөлт 2022 оны 1 дүгээр улирал хүртэлх хугацаанд саарч, 2022 оны 2 дугаар улиралд өсөж 2.0 хувьд хүрч байсан бол 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 2.4 хувийн өсөлттэй гарлаа.

График 1-д 2018-аас 2025 оны 1 дүгээр улирлын байдлаарх ДНБ-ий хэмжээ болон мөн хугацааны улирал бүрийн эдийн засгийн бодит өсөлтийн хоорондох хамаарлыг харуулав.

График 1. Нэрлэсэн ДНБ-ий хэмжээ ба ДНБ-ий бодит өсөлт, улирлаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 19.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.2 хувь буюу 2.5 их наяд төгрөгөөр, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ-ий хэмжээ 6.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.4 хувь буюу 143.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Эдийн засгийн өсөлтөд барилга, тээвэр ба агуулах үйл ажиллагаа, цэвэр татвараас бусад салбар эерэг хувь нэмэр оруулжээ.

Хөдөө аж ахуйн салбар 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 35.6 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 1.02 нэгж хувийг, худалдаа, үйлчилгээний салбар 34.9 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 2.6 нэгж хувийг бүрдүүлжээ.


Харин бусад салбаруудын хувьд өмнөх оны мөн үеэс 0.2-48.5 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, салбаруудын оролцоо /хувь/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын гүйцэтгэл							
	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
ДНБ	6.3	8.6	-10.1	14.8	-3.8	8.0	7.9	2.4
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	4.6	1.1	12.0	-4.5	11.3	-5.1	-24.8	35.6
Уул уурхай, олборлолт	3.8	15.5	-32.9	38.5	-38.9	48.7	13.3	0.8
Боловсруулах үйлдвэрлэл	10.5	4.3	1.2	23.8	-10.1	-6.8	4.9	3.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	9.1	2.7	5.5	6.8	6.1	4.0	7.7	5.5
Барилга	14.2	14.3	13.0	-0.4	-29.8	1.2	27.7	-1.1
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	3.9	16.4	-13.6	6.1	8.5	10.0	6.0	5.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-2.3	10.2	-31.0	18.7	-31.9	76.6	26.9	-21.6
Мэдээлэл, холбоо	1.5	15.8	5.2	13.7	14.7	5.4	27.5	16.5
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5.4	4.6	-3.0	0.8	4.3	1.6	3.4	7.1
Бүтээгдэхүүний цэвэр татвар	17.4	8.8	-8.1	46.4	9.8	-3.7	13.1	-2.3


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 2. Нэрлэсэн ДНБ, өөрчлөлт, оны үнээр, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 3. Бодит ДНБ, өөрчлөлт, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ:

Оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 19.0 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 11.5 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 6.8 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 2.4 хувиар тус тус өссөн байна.



Хүснэгт 2. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр, өссөн дүнгээр

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2019-И	2020-И	2021-И	2022-И	2023-И	2024-И	2025-И	Өөрчлөлт (хувиар)
ДНБ	7,665.2	7,133.6	9,084.9	9,700.8	14,695.1	17,079.7	19,045.4	11.5
Эцсийн хэрэглээ	6,166.3	6,975.7	6,316.1	7,768.3	9,036.4	11,977.4	14,298.5	19.4
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	5,075.4	5,707.6	5,194.0	6,425.3	7,178.8	9,042.2	11,251.1	24.4
Төрийн байгууллагын хэрэглээ	1,090.9	1,268.1	1,122.1	1,343.0	1,857.6	2,935.2	3,047.4	3.8
Хөрөнгийн нийт хуримтлал	1,980.9	2,003.6	2,491.0	3,409.3	3,505.7	4,727.0	6,609.0	39.8
Үндсэн хөрөнгийн хуримтлал	1,949.8	1,768.6	2,028.6	2,364.5	3,007.0	3,568.7	5,142.1	44.1
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	31.1	234.9	462.4	1,044.8	498.7	1,158.3	1,466.9	26.6
Цэвэр экспорт	-482.0	-1,845.7	277.9	-1,476.9	2,153.0	375.4	-1,862.1	-596.1
Бараа, үйлчилгээний экспорт	4,974.3	2,836.2	5,930.0	5,159.8	12,566.4	12,565.4	10,976.8	-12.6
Бараа, үйлчилгээний импорт	5,456.3	4,681.9	5,652.1	6,636.6	10,413.4	12,190.1	12,838.9	5.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 3. Эцсийн ашиглалтын аргаар ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, өссөн дүнгээр

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2019-И	2020-И	2021-И	2022-И	2023-И	2024-И	2025-И	Өөрчлөлт (хувиар)
ДНБ	5,481.7	5,081.6	5,849.1	5,705.8	6,155.7	6,645.7	6,807.3	2.4
Эцсийн хэрэглээ	5,298.7	5,699.0	5,047.5	5,478.9	5,711.0	6,875.5	7,434.1	8.1
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	4,348.7	4,637.5	4,098.7	4,479.9	4,596.7	5,377.7	6,018.4	11.9
Төрийн байгууллагын хэрэглээ	950.0	1,061.5	948.8	999.0	1,114.3	1,497.8	1,415.7	-5.5
Хөрөнгийн нийт хуримтлал	1,643.4	1,473.8	1,904.5	2,501.4	2,126.5	2,960.1	3,556.1	20.1
Үндсэн хөрөнгийн хуримтлал	1,616.3	1,367.9	1,534.4	1,562.8	1,790.2	2,166.5	2,824.6	30.4
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	27.1	105.9	370.1	938.7	336.3	793.7	731.5	-7.8
Цэвэр экспорт	-1,460.4	-2,091.3	-1,102.8	-2,274.5	-1,681.8	-3,189.9	-4,182.9	31.1
Бараа, үйлчилгээний экспорт	2,993.4	1,716.9	3,123.0	2,207.3	4,740.6	4,299.7	3,526.0	-18.0
Бараа, үйлчилгээний импорт	4,453.8	3,808.2	4,225.9	4,481.8	6,422.4	7,489.6	7,708.9	2.9

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 4. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, их наяд төгрөгөөр

1.2. Нэг ажилтанд ногдох ДНБ

Хөдөлмөрийн бүтээмжийг нэг ажиллагчид ногдох ДНБ-ий хэмжээ буюу хөдөлмөрийн бүтээмжийн түвшингээр тооцно. Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 4.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар буюу 54.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Салбараар нь авч үзвэл, уул уурхайн салбарын бүтээмж 383.0 мянган төгрөг (3.5 хувь)-өөр, хөдөө аж ахуйн салбарын бүтээмж 112.9 мянган төгрөг (22.3 хувь)-өөр, үйлчилгээний салбарын бүтээмж 110.5 мянган төгрөг (2.6 хувь)-өөр тус тус нэмэгдсэн бол аж үйлдвэр, барилгын салбарын бүтээмж 92.2 мянган төгрөг (3.0 хувь)-өөр буурчээ.

Хүснэгт 5. Нэг хүнд ногдох ДНБ буюу бүтээмжийн харьцуулалт

Бүрэлдэхүүн	1 дүгээр улирлын гүйцэтгэл							/мянган төгрөгөөр/	
	2019	2020	2021	2022	2023	2024	2025	Өөрчлөлт, 2025.03/2024.03	
								Дүн	Хувь
Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин	4,030.8	3,482.5	4,404.7	3,950.3	4,229.4	4,314.8	4,260.3	- 54.5	-1.3
Хөдөө аж ахуй	536.0	680.6	617.2	681.7	629.8	506.6	619.6	112.9	22.3
Уул уурхай, олборлолт	13,508.1	11,037.0	15,714.1	8,458.2	11,053.2	11,049.6	11,432.6	383.0	3.5
Аж үйлдвэр, барилга	3,647.0	3,088.2	3,658.5	3,005.7	3,199.0	3,068.9	2,976.5	- 92.3	-3.0
Үйлчилгээ	4,178.6	3,469.9	4,372.3	4,177.2	4,411.0	4,296.9	4,407.3	110.5	2.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 6,149.7 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 6,502.7 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 353.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 1,172.2 тэрбум төгрөг буюу 16.0 хувиар буурсан бол төсвийн нийт зарлага 807.3 тэрбум төгрөг буюу 14.2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Монгол Улсын нэгдсэн төсөв

Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл		Биелэлт, хувиар	/тэрбум төгрөгөөр/	
					Өөрчлөлт(+/-)	
					2025.03/2024.03	
					(3-2)	(3-2)/2
	1	2	3	(3:1)	Дүн	Хувь
2025.03	2024.03	2025.03	Гүйц/төл			
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	6,721.5	7,321.9	6,149.7	91.5	-1,172.2	-16.0
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	9,535.7	5,695.3	6,502.7	68.2	807.3	14.2
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-2,814.3	1,626.5	-353.0	12.5	-1,979.5	-121.7
ДНБ, оны үнээр		16,464.9	18,968.5		2,503.6	15.2
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь		9.9	-1.9		-11.7	

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын бүрдүүлэлт 91.5 хувийн, нийт зарлага 68.2 хувийн гүйцэтгэлтэй гарч, нийт тэнцэл -353.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2.1. Нэгдсэн төсвийн орлого:

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламж 6,149.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар буюу 1,172.2 тэрбум төгрөгөөр буурч, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 8.5 хувь буюу 571.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрчээ.

Тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал тус бүрээр авч үзвэл улсын төсөв 12.5 хувь буюу 524.5 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 18.2 хувь буюу 373.7 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 5.6 хувь буюу 37.0 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн бол нийгмийн даатгалын сангийн төсөв 2.0 хувь буюу 31.2 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 30.3 хувь буюу 1,598.1 тэрбум төгрөгөөр бага байгаа бол, орон нутгийн төсөв 14.7 хувь буюу 215.9 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сан 25.1 хувь буюу 315.5 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 43.1 хувь буюу 187.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 7. Нэгдсэн төсвийн орлогын 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

/тэрбум төгрөгөөр/

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС		ҮБС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
Нийт орлого ба тусламжийн дүн	4,269.2	3,745.9	2,057.3	1,683.6	1,542.3	1,573.5	658.2	621.2	282.4	208.9
Ирээдүй өв сан	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	282.4	208.9
Хуримтлалын сан	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сан	72.5	73.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	4,196.8	3,672.2	2,057.3	1,683.6	1,542.3	1,573.5	658.2	621.2	0.0	0.0
Татварын орлого	3,366.9	3,198.0	1,698.5	1,412.3	1,114.8	1,146.0	658.2	621.2	0.0	0.0
Татварын бус орлого	829.8	474.2	358.7	271.3	427.5	427.5	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 94.2 хувийг татварын орлого, 5.8 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Хүснэгт 5. Татварын болон татварын бус орлого /хувиар/



2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр Тогтворжуулалтын санд 72.5 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 282.4 тэрбум төгрөг хуваарилахаар төлөвлөснөөс Тогтворжуулалтын санд 73.7 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 208.9 тэрбум төгрөг хуваарилсан байна. Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлого 101.7 хувийн биелэлттэй буюу 1.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол, Ирээдүйн өв сангийн хөрөнгө 74.0 хувийн биелэлттэй буюу 73.5 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

Хүснэгт 8. Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, Тогтворжуулалтын сангийн 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл


Үзүүлэлт	ӨОМУ	Төсөв	Гүйцэтгэл	Төсвөөс		ӨОМУ-ээс	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Ирээдүй өв сан	284.0	282.4	208.9	-73.5	-26.0	-75.2	-26.5
Хуримтлалын сан	0.0	0.0	0.0	0.0		0.0	
Тогтворжуулалтын сан	67.5	72.5	73.7	1.2	1.7	6.2	9.2

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн татварын орлого 5,795.4 тэрбум төгрөг болж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 92.9 хувийн биелэлттэй байгаа ба өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар буюу 1,113.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Татварын орлого: Татварын орлогын 34.8 хувийг орлогын албан татвар, 20.4 хувийг нийгмийн даатгалын орлого, 2.4 хувийг хөрөнгийн албан татвар, 21.6 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 5.1 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 6.8 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 8.7 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлсэн байна.

График 6. Татварын орлого /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Сангийн яам

2024 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн татварын орлого төлөвлөснөөс 7.1 хувь буюу 439.9 тэрбум төгрөгөөр дутуу биелэсэн байна. Үүнд:

- нийгмийн даатгалын орлого 1.3 хувь (15.2 тэрбум төгрөг),
- онцгой албан татвар 2.1 хувь (6.0 тэрбум төгрөг)-аар тус тус давж биелсэн.

Харин дутуу биелсэн татварын орлогод дараах татвар хамаарч байна. Үүнд:

- орлогын албан татвар 8.9 хувь (197.3 тэрбум төгрөг),
- хөрөнгийн албан татвар 8.2 хувь (12.5 тэрбум төгрөг),
- нэмэгдсэн өртгийн албан татвар 9.2 хувь (126.6 тэрбум төгрөг),
- тусгай зориулалтын орлого 26.0 хувь (2.3 тэрбум төгрөг),
- гадаад үйл ажиллагааны орлого 9.7 хувь (42.4 тэрбум төгрөг),
- бусад татвар, төлбөр, хураамж 13.6 хувь (79.9 тэрбум төгрөг) зэрэг болно.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2024 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр

- нийгмийн даатгалын орлого 28.8 хувь (264.9 тэрбум төгрөг),
- хөрөнгийн албан татвар 29.1 хувь (31.7 тэрбум төгрөг),
- онцгой албан татвар 5.2 хувь (14.5 тэрбум төгрөг),
- тусгай зориулалтын орлого 1.5 хувь (0.1 тэрбум төгрөг),
- гадаад үйл ажиллагааны орлого 12.1 хувь (42.4 тэрбум төгрөг)-аар тус тус өссөн бол
- орлогын албан татвар 21.1 хувь (539.7 тэрбум төгрөг),
- нэмэгдсэн өртгийн албан татвар 2.8 хувь (35.6 тэрбум төгрөг),
- бусад татвар, төлбөр, хураамж 63.8 хувь (891.7 тэрбум төгрөг)-аар тус тус буурчээ.

Татварын бус орлого: 2024 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр татварын бус орлого 354.3 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 58.7 тэрбум төгрөгөөр буюу 14.2 хувиар, төлөвлөснөөс 131.9 тэрбум төгрөг буюу 27.1 хувиар дутуу төвлөрчээ.

Татварын бус орлогын 92.3 хувийг нийтлэг татварын бус орлого, 7.4 хувийг тусламжийн орлого, 0.3 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогыг бүтцийн хувьд авч үзвэл 37.8 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 17.8 хувийг газрын тосны орлого, 17.2 хувийг торгуулийн орлого, 13.2 хувийг хүүгийн орлого, 10.7 хувийг бусад орлого, 3.1 хувийг навигацийн орлого, 0.2 хувийг түрээсийн орлого тус тус бүрдүүлж байна.

График 7. Татварын бус орлогын бүтэц, хувиар



Эх сурвалж: Сангийн яам

Төлөвлөгөөтэй харьцуулахад гадаад хандив тусламжийн орлого 53.2 тэрбум төгрөгөөр, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 0.6 тэрбум төгрөгийн дутуу биелэлтэй байна.

Нийтлэг татварын бус орлогоос хүүгийн орлого 10.1 тэрбум төгрөг, торгуулийн орлого 8.0 тэрбум төгрөг, хувьцааны ногдол ашгийн орлого 0.2 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн бол бусад орлого 49.2 тэрбум төгрөг, газрын тосны орлого 28.8 тэрбум төгрөг, навигацийн орлого 9.9 тэрбум төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 7.6 тэрбум төгрөг, түрээсийн орлого 0.6 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрчээ.

2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 9,535.7 тэрбум төгрөг төлөвлөснөөс 68.2 хувийн зарцуулалтай буюу 3,033.1 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 807.3 тэрбум төгрөг буюу 14.2 хувиар өсөж, 6,502.7 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Хүснэгт 9. Нэгдсэн төсвийн зарлага

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	ӨО-ны мөн үеийн /2024.01/	2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,695.3	9,535.7	6,502.7	68.2	-3,033.1
НИЙТ ЗАРЛАГА	5,540.9	9,396.2	6,492.8	69.1	-2,903.4
УРСГАЛ ЗАРДАЛ	4,698.0	7,186.3	5,900.4	82.1	-1,286.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,768.1	3,099.4	2,231.9	72.0	-867.5
ХҮҮ	401.8	446.8	408.1	91.3	-38.7
ТАТААС	133.8	301.0	243.4	80.9	-57.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,394.3	3,339.2	3,017.0	90.4	-322.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	842.9	2,209.9	592.4	26.8	-1,617.5
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	154.4	139.5	9.9	7.1	-129.6

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн урсгал зардал 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.6 хувиар буюу 1,202.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нэгдсэн төсвийн зарлагын 90.7 хувь буюу 5,900.4 тэрбум төгрөг нь урсгал зардал, үүний дотор 51.1 хувийг урсгал шилжүүлэг, 37.8 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 6.9 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 4.1 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал шилжүүлэг 622.7 тэрбум төгрөг, бараа, ажил үйлчилгээний зардал 463.8 тэрбум төгрөг, татаас 109.7 тэрбум төгрөгөөр, зээлийн үйлчилгээний төлбөр 6.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Түүнчлэн хөрөнгө оруулалтын зардал 250.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн өмнөх оны мөн үеэс 16.0 хувь буюу 1,172.2 тэрбум төгрөгөөр буурсан бол нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 14.2 хувь буюу 807.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1,979.5 тэрбум төгрөгөөр өсжээ.

ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “Засгийн газрын өр”-ийг тодорхойлсон, тухайлбал 4.1.8.а-д өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг, 4.1.8.б-д хууль болон гэрээнд заасны дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгааны дүнг” гэж тодорхойлсон. Засгийн газрын дотоод өр гэж өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газраас бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг, Засгийн газрын гадаад өр гэж Монгол Улсын Засгийн газрын эдийн засгийн харьяат бус аливаа этгээдэд төлөх өрийн хэрэгслээр үүсгэгдсэн төлбөрийн үүргийг тус тус ойлгоно.

Хүснэгт 10. Засгийн газрын өр

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын гүйцэтгэл							
	2018	2019	2020	2021	2022	2023	2024*	2025*
I.Засгийн газрын дотоод өр (өрийн хэрэгслээр)	2,706.0	1,533.5	1,359.4	1,136.6	657.2	836.6	196.6	406.8*
Үнэт цаас	2,706.0	1,533.5	1,359.4	1,136.6	657.2	836.6	196.6	406.8
II.Засгийн газрын гадаад өр ¹ (өрийн хэрэгслээр)	16,636.7	18,927.9	21,180.1	24,390.0	25,436.5	31,319.8	29,541.4	31,410.8
Үнэт цаас	7,288.2	7,631.4	8,050.1	8,354.4	8,450.5	10,592.3	8,703.3	8,737.6
Зээл	9,348.5	11,296.4	13,130.0	16,035.6	16,985.9	20,727.5	20,838.1	22,673.2
III.Засгийн газрын бусад өр	2,140.0	1,889.0	2,012.6	1,806.1	1,448.7	1,252.7	29.2	2,798.5
Засгийн газрын өрийн баталгаа	1,549.6	1,084.6	1,055.5	964.2	815.7	778.7	29.2	184.7
Барих-шилжүүлэх концесс	590.4	804.4	957.1	841.9	633.0	474.0	-	-
Орон нутгийн зээллэг								2,613.8
Засгийн газрын нийт өр (I+II+III)	21,482.7	22,350.4	24,552.1	27,332.7	27,542.4	33,409.1	29,767.2	34,616.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Сангийн яам*


Засгийн газрын өрийн хэмжээ 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 34,616.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,849.1 тэрбум төгрөгөөр буюу 16.3 хувиар өссөн байна. Үүнд; Засгийн газрын дотоод үнэт цаас 210.2 тэрбум төгрөг буюу 106.9 хувиар, Засгийн газрын гадаад өр 1,869.4 тэрбум төгрөгөөр буюу 6.3 хувиар, Засгийн газрын бусад өр 2,769.3 тэрбум төгрөг буюу 95.8 дахин өссөн байна.

Засгийн газрын өрийн хэмжээг ковидын өмнөх үе буюу 2019 оны мөн үетэй харьцуулж үзэхэд 12,265.9 тэрбум төгрөгөөр буюу 54.9 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь Засгийн газрын гадаад өрийн 12,482.9 тэрбум төгрөг буюу 65.9 хувийн өсөлт (гадаад үнэт цаас 1,106.2 тэрбум төгрөг буюу 14.5 хувь, гадаад зээл 11,376.8 тэрбум төгрөг буюу 100.7 хувь)-тэй холбоотой байна.

ДӨРӨВ. ГАДААД ХУДАЛДАА

2025 оны эхний улирлын гүйцэтгэлээр Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 5,561.6 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 503.5 сая ам.доллар буюу 8.3 хувиар буурсан байна. Өмнөх оны мөн үеэс гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ буурсан хэдий ч гадаад худалдааны тэнцэл 464.3 сая ам.долларын ашигтай гарлаа.

График 8. Гадаад худалдааны үзүүлэлт, 2019.03-2025.03 он /сая ам.доллар/



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

4.1. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд

2025 оны эхний улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 5,561.6 сая ам.доллар, экспортын худалдаа 3,013.0 сая ам.доллар, импортын худалдаа 2,548.6 сая ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 464.3 сая ам.долларын ашигтай гарсан байна.

2018-2025 оны эхний 3 сарын гүйцэтгэлийг харьцуулж үзэхэд, экспортын дундаж өсөлт 10.7 хувь, импортынх 12.3 хувь байгаа нь гадаад худалдааны нийт бараа эргэлт болон гадаад худалдааны ашиг нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2025 оны эхний улирлын гүйцэтгэлээр экспорт 537.6 сая ам.доллар буюу 17.5 хувиар буурч, харин импорт 134.1 сая ам.доллар буюу 5.6 хувиар өссөн нь гадаад худалдааны нийт бараа эргэлт 503.5 сая ам.доллар буюу 8.3 хувиар, мөн гадаад худалдааны тэнцэл 771.7 сая ам.доллар буюу 62.4 хувиар буурахад нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 11. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлт, 2020-2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл

Үзүүлэлт	1 дүгээр улирлын гүйцэтгэл					/сая ам.доллар/ Өөрчлөлт	
	2021	2022	2023	2024	2025	Дүн	Хувь
Нийт эргэлт	3,522.4	3,596.7	5,706.0	6,065.1	5,561.6	-503.5	-8.3
Экспорт	1,999.7	1,906.0	3,766.4	3,650.6	3,013.0	-637.6	-17.5
Импорт	1,522.7	1,690.7	1,939.6	2,414.5	2,548.6	134.1	5.6
Тэнцэл	477.0	215.3	1,826.8	1,236.0	464.3	-771.7	-62.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл:

2025 оны эхний улирлын байдлаар гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 771.7 сая ам.доллар буюу 62.4 хувиар буурч, 464.3 сая ам.долларын ашигтай гарсан. Импортыг экспортоор нөхөх коэффициент 2024 оны эхний 3 сарын байдлаар 194.1 хувь, 2024 оны эхний 3 сард 151.6 хувь байсан бол 2025 оны эхний 3 сарын байдлаар 118.3 хувь болж, буурсан байна.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл: 2025 оны эхний улирлын гүйцэтгэлээр валютын төлбөртэй экспорт нийт экспортын орлогын 99.1 хувь, валютын төлбөртэй импорт нь нийт импортын худалдааны 97.6 хувийг тус тус эзэлж байна.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2025 оны эхний улирлын гүйцэтгэлээр 499.8 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 763.4 сая ам.доллар буюу 60.4 хувиар буурсан байна. Өнгөрсөн оны мөн үеэс валютын төлбөртэй экспортын орлого 623.6 сая ам.доллар буюу 17.3 хувиар буурч, харин валютын төлбөртэй импорт 139.8 сая ам.доллар буюу 6.0 хувиар нэмэгдсэн нь валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл буурахад нөлөөлжээ.


Хүснэгт 12. Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл

Үзүүлэлт	1 дүгээр улирлын гүйцэтгэл			/сая.ам.доллараар/ Харьцуулсан хувь (2025.03/2024.03)
	2023	2024	2025	Хувь
НИЙТ БАРАА ЭРГЭЛТ	5,706.0	6,065.1	5,561.6	-8.3
А.Экспорт	3,766.4	3,650.6	3,013.0	-17.5
А1.Валютын төлбөртэй бараа	3,740.0	3,610.1	2,986.5	17.3
Валютын төлбөртэй экспортын нийт экспортод эзлэх хувь	99.3	98.9	99.1	-
В.Импорт	1,939.6	2,414.5	2,548.6	5.6
В1.Валютын төлбөртэй бараа	1,869.6	2,346.9	2,486.7	6.0
Валютын төлбөртэй импортын нийт импортод эзлэх хувь	96.4	97.2	97.6	-
С. Тэнцэл (А-В):	1,826.8	1,236.0	464.3	-62.4
D. Импортыг экспортоор нөхөх коэффициент ((А/В)*100)	194.1	151.6	118.3	-

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Экспорт, импортын жилийн өсөлт: Экспорт болон импортын жилийн өсөлтийн хурдыг 3 сарын гулсах дундаж (2011.01-2025.03)-аар тооцон үзэв.

График 9. Гадаад худалдааны үзүүлэлтүүдийн өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Хөрш орнууд (ОХУ, БНХАУ) монголын гадаад худалдаанд томоохон үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, 2025 оны эхний улирлын гүйцэтгэлээр хөрш орнууд нийлээд Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 77.9 хувь, экспортын 92.7 хувь, импортын 60.5 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс:

- БНХАУ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 65.0 хувь, экспортын 92.2 хувь, нийт импортын 32.9 хувийг эзэлж байна.
- ОХУ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 12.9 хувь, экспортын 0.5 хувь, нийт импортын 27.6 хувийг эзэлж байна.
- БНХАУ-тай хийсэн худалдаа 1,938.9 сая ам.долларын ашигтай, ОХУ-тай хийсэн худалдаа 687.3 сая ам.долларын алдагдалтай байна.
- Бусад улс оронтой хийсэн худалдаа гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 22.1 хувь, экспортын 7.3 хувь, импортын 39.5 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 13. Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Улс орон	Үзүүлэлт	Эзлэх хувь /2025.03 сар/	1 дүгээр улирлын гүйцэтгэл			Өөрчлөлт (+/-)	
			2023	2024	2025	2025.03/2024.03	
						Дүн	Хувь
БНХАУ	Нийт эргэлт	65.0	4,217.5	4,192.0	3,617.2	-574.9	-13.7
	Экспорт	92.2	3,476.4	3,335.2	2,778.0	-557.1	-16.7
	Импорт	32.9	741.2	856.9	839.1	-17.7	-2.1
	Тэнцэл	-	2,735.2	2,478.3	1,938.9	-539.4	-21.8
ОХУ	Нийт эргэлт	12.9	539.4	710.1	717.3	7.2	1.0
	Экспорт	0.5	21.9	29.4	15.0	-14.4	-49.1
	Импорт	27.6	517.5	680.7	702.3	21.6	3.2
	Тэнцэл	-	-495.6	-651.3	-687.3	-36.0	5.5
Бусад	Нийт эргэлт	22.1	949.1	1,162.9	1,227.1	64.20	5.5
	Экспорт	7.3	268.1	286.0	220.0	-66.03	-23.1
	Импорт	39.5	681.0	876.9	1,007.2	130.24	14.9
	Тэнцэл	-	-412.8	-590.9	-787.2	-196.27	33.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо

4.2. Экспорт:

2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр экспортын худалдаа 3,013.0 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 637.6 сая ам.доллар буюу 17.5 хувиар буурсан байна.

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар эрдэс бүтээгдэхүүний экспорт 2,685.5 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 560.8 сая ам.доллар буюу 17.3 хувиар буурсан байна. 2025 оны эхний улирлын гүйцэтгэлээр эрдсийн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жин 89.1 хувь, эрдсээс бусад бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь 11.9 хувь байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт 2025 оны эхний улиралд 327.4 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 76.8 сая ам.доллар буюу 19.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 14. Экспорт, бүлгээр /2021.03-2025.03/

/сая ам.доллар/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын гүйцэтгэл					Өөрчлөлт	
	2021	2022	2023	2024	2025	Дүн	Хувь
Нийт экспорт	1,999.7	1,906.0	3,766.4	3,650.6	3,013.0	-637.6	-17.5
Үүнээс:							
1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт	1,776.1	1,531.0	3,333.9	3,246.3	2,685.5	-560.8	-17.3
Эрдэс бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь	88.8	80.3	88.5	88.9	89.1	-	-
2. Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	223.6	375.0	432.5	404.2	327.4	-76.8	-19.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүнд нүүрс, зэсийн баяжмал, алт, төмрийн хүдэр, түүхий газрын тос, жоншны баяжмал, цайрын баяжмал зэрэг бүтээгдэхүүн хамаарч байна.

Нийт экспортын орлогын 44.5 хувийг нүүрс, 30.9 хувийг зэсийн баяжмал, 5.6 хувийг алт, 4.3 хувийг төмрийн хүдэр, 2.9 хувийг жоншны баяжмал, 2.3 хувийг боловсруулаагүй нефть болон 2.1 хувийг цайрын баяжмал тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс, алт, газрын түүхий тос болон төмрийн хүдрийн экспортын орлого буурсан, харин бусад эрдсийн бүтээгдэхүүний экспортын орлого өссөн байна.

Хүснэгт 15. Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Гол нэр төрлийн бараа	1 дүгээр улирлын гүйцэтгэл					Өөрчлөлт	
	2021	2022	2023	2024	2025	Дүн	Хувь
Нүүрс (сая.т)	6.8	2.5	14.2	18.1	17.5	-0.6	-3.3
Зэсийн баяжмал(мян.т)	316.3	334.8	362.9	367.4	456.2	88.8	24.2
Алт (тн)	0.4	4.8	2.6	3.1	1.9	-1.3	-40.6
Төмрийн хүдэр (сая.т)	1.9	0.6	1.3	1.8	1.8	0.0	-2.1
Боловсруулаагүй нефть (сая.барр)	1.4	0.0	1.2	1.1	0.9	-0.1	-12.9
Жоншны баяжмал (мян.т)	194.1	50.9	175.9	267.7	404.6	136.9	51.1
Цайрын баяжмал (мян.т)	31.0	21.9	57.9	18.6	40.9	22.3	119.6
Молибдены баяжмал (мян.т)	1.6	1.1	1.8	1.6	1.6	0.1	3.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 16. Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/


Гол нэр төрлийн бараа	Экспортод эзлэх хувь	1 дүгээр улирлын гүйцэтгэл					Өөрчлөлт	
		2021	2022	2023	2024	2025	Дүн	Хувь
Нүүрс	44.5	692.2	675.2	2272.3	2225.0	1342.1	-882.9	-39.7
Зэсийн баяжмал	30.9	621.1	710.9	631.6	638.1	929.9	291.8	45.7
Алт	5.6	25.7	288.0	156.0	213.9	167.3	-46.5	-21.8
Төмрийн хүдэр	4.3	238.5	57.5	108.4	144.7	128.3	-16.4	-11.3
Боловсруулаагүй нефть	2.3	78.4	0.0	88.5	82.6	69.1	-13.5	-16.4
Жоншны баяжмал	2.9	42.6	11.5	44.0	58.2	87.5	29.3	50.3
Цайрын баяжмал	2.1	46.4	41.2	98.1	23.7	63.5	39.7	167.6
Молибдены баяжмал	0.9	11.9	15.2	38.3	22.9	26.5	3.6	15.7

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Экспортын гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

Зэсийн баяжмал: 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 456.2 мянган тонн зэсийн баяжмал экспортолж, 929.9 сая ам.долларын экспортын орлого олсон нь өнгөрсөн оны мөн үеэс 291.8 сая ам.доллар буюу 45.5 хувиар өссөн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмалын экспортын тоо хэмжээ 88.8 мянган тонн буюу 24.2 хувиар, зэсийн баяжмалын хилийн үнэ 17.4 хувиар тус тус өссөн нь экспортын орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.


График 10.Зэсийн баяжмалын экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төмрийн хүдэр, баяжмал: 2025 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр 128.3 сая ам.долларын 1.8 сая. тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 16.2 сая ам.доллар буюу 11.2 хувиар, биет хэмжээ 2.0 хувиар тус тус буурсан байна. Нэг тонн төмрийн хүдэр, баяжмалын экспортын дундаж үнэ 72.6 ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 7.6 хувиар буурсан байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

График 11. Төмрийн хүдрийн экспортын өөрчлөлт




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Алт: 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 1.9 тонн алт экспортолж, 167.3 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өнгөрсөн оны мөн үеэс алтны экспортын орлого 46.5 сая ам.доллар буюу 21.8 хувиар буурсан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад алтны үнэ 31.7 хувиар өссөн боловч экспортын биет тоо хэмжээ буурсан нь алтны экспортын орлого буурахад нөлөөлсөн байна.

Боловсруулаагүй нефть: 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 0.9 сая баррель боловсруулаагүй нефть экспортолж, 69.1 сая ам.долларын орлого олсон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад боловсруулаагүй нефтийн экспортын орлого 13.5 сая ам.доллар буюу 16.4 хувиар буурсан байна. Үүнд боловсруулаагүй нефтийн тоо хэмжээ 12.9 хувь, үнэ 3.9 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн.

Нүүрс: 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 17.5 сая тонн нүүрс экспортолж, 1.3 тэрбум ам.долларын экспортын орлого олжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад экспортын биет хэмжээ 0.6 сая тонн буюу 3.3 хувиар, нүүрсний экспортын хилийн үнэ 37.6 хувиар тус тус буурсан нь нүүрсний экспортын орлого 882.9 сая ам.доллар буюу 39.7 хувиар багасахад нөлөөлжээ. 2025 оны эхний 3 сарын дундажаар сард 5.8 сая тонн нүүрс экспортжээ. 2024 оны мөн үетэй харьцуулахад нүүрсний хилийн дундаж үнэ 37.6 хувиар буурч, 76.5 ам.долл/тн-оор борлуулсан байна.

График 12. Нүүрсний экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Жоншны баяжмал: 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр жоншны баяжмалын экспортын тоо хэмжээ 404.6 мянган тонн-д хүрч, 87.5 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Жоншны баяжмалын биет хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 51.1 хувь буюу 136.9 мянган тонноор өссөн нь жоншны экспортын орлого өсөхөд голлон нөлөөлжээ.

Цайрын баяжмал: 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ 40.9 мянган тонн-д хүрч, 63.5 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад цайрын баяжмалын биет хэмжээ 22.3 мянган тонноор, хилийн үнэ 21.9 хувиар тус тус өсөж, улмаар цайрын баяжмалын экспорт өмнөх оны мөн үеэс 39.7 сая ам.доллар нэмэгдсэн байна.

4.3. Импорт:

2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр импортын худалдаа 2,548.6 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 5.6 хувь буюу 134.1 сая ам.доллараар өссөн байна.

2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр нийт импортын 24.7 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 75.3 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний импорт 629.5 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 4.9 сая ам.доллар буюу 0.8 хувиар өсчээ. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 1,919.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 129.2 сая ам.доллар буюу 7.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 17. Импорт, бүлгээр /2021.03-2025.03/

/сая ам.доллар/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын гүйцэтгэл					Өөрчлөлт	
	2021	2022	2023	2024	2025	Дүн	Хувь
Нийт импорт	1,522.7	1,690.7	1,939.6	2,414.5	2,548.6	134.1	5.6
Үүнээс:							
1. Эрдэс бүтээгдэхүүний импорт	275.7	386.5	484.0	624.5	629.5	4.9	0.8
Эрдэс бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь	18.1	22.9	25.0	25.9	24.7	-	-
2. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	1,247.0	1,304.2	1,455.6	1,790.0	1,919.1	129.2	7.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр нийт импортын 35.0 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 35.4 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 7.4 хувийг аж үйлдвэрлэлийн орц, 22.0 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2025 оны эхний улирлын байдлаар импортын худалдаа нэмэгдэхэд хэрэглээ 167.0 сая ам.доллар буюу 23.0 хувиар өссөн нь нөлөөлжээ.


Хүснэгт 18. Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл

/сая ам.доллар/

Бүтээгдэхүүн	1 дүгээр улирлын гүйцэтгэл						Өөрчлөлт (сая ам.дол)
	2023		2024		2025		2025.03/ 2024.04
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	
Хэрэглээ	573.0	29.5	726.0	30.1	893.0	35.0	167.0
- Түргэн эдэлгээтэй	296.0	15.3	314.0	13.0	353.0	13.9	39.0
- Удаан эдэлгээтэй	277.0	14.3	412.0	17.1	540.0	21.2	128.0
Хөрөнгө оруулалт	752.0	38.8	904.0	37.4	901.0	35.4	-3.0
- Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	521.0	26.9	636.0	26.3	614.0	24.1	-22.0
- Барилгын материал	164.0	8.5	189.0	7.8	223.0	8.7	34.0
- Хөрөнгө оруулалтын бусад бараа	67.0	3.5	79.0	3.3	64.0	2.5	-15.0
Аж үйлдвэрлэлийн орц	189.0	9.7	222.0	9.2	188.0	7.4	-34.0
Нефтийн бүтээгдэхүүн	424.0	21.9	557.0	23.1	560.0	22.0	3.0
- Дизель	261.0	13.5	337.0	14.0	359.0	14.1	22.0
- АИ-92, 95	111.0	5.7	165.0	6.8	161.0	6.3	-4.0
- А80 ба бусад	52.0	2.7	55.0	2.3	40.0	1.6	-15.0
Бусад	3.0	0.2	4.0	0.2	5.0	0.2	1.0
Нийт дүн	1,941.0	100.0	2,413.0	100.0	2,547.0	100.0	134.0

Эх сурвалж: Монголбанк

Нефтийн бүтээгдэхүүний импорт нь өнгөрсөн оны мөн үеэс 3.0 сая ам.доллараар өссөн байна. Дизель түлшний импорт 22.0 сая ам.доллараар нэмэгджээ. 2025 оны 3 сард нефтийн бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 110.8 ам.дол/баррель байна.

График 13. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ /ам.доллар/баррель/

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТАВ. МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

5.1. Мөнгөний нийлүүлэлт:

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар мөнгөний нийлүүлэлт 41,483.4 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 4,084.9 тэрбум төгрөг буюу 10.9 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үеэс мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд төгрөгийн хадгаламж 3,992.1 тэрбум төгрөг буюу 22.0 хувь, валютын хадгаламж 466.6 тэрбум төгрөг буюу 10.4 хувь, төгрөгийн харьцах 260.0 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 19. Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	1 дүгээр улирлын гүйцэтгэл			Өөрчлөлт (+/-)	
				2025.03/2024.03	
	2023	2024	2025	Дүн	Хувь
Мөнгөний нийлүүлэлт (M2)	30,938.8	37,398.5	41,483.4	4,084.9	10.9
Мөнгө M1	6,792.2	9,789.5	10,137.9	348.4	3.6
Төгрөгийн харилцах	6,024.8	8,962.1	9,222.1	260.0	2.9
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	767.4	827.4	915.9	88.5	10.7
Бараг мөнгө	24,146.6	27,609.0	31,345.5	3,736.5	13.5
Төгрөгийн хадгаламж	13,090.5	18,144.6	22,136.7	3,992.1	22.0
Валютын хадгаламж	5,954.8	4,497.3	4,963.9	466.6	10.4
Валютын харилцах	5,101.2	4,967.0	4,244.8	-722.2	-14.5
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө	1,036.5	1,091.4	1,189.5	98.1	9.0

Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 38.8 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 9.7 их наяд төгрөг буюу 33.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 20. Зээлийн өрийн үлдэгдэл

Үзүүлэлт	1 дүгээр улирлын гүйцэтгэл			Өөрчлөлт (+/-)	
				2025.03/2024.03	
	2023	2024	2025	Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	23,230.8	29,139.4	38,859.4	9,720.0	33.4
-Хэвийн зээл	19,621.7	25,821.9	35,270.8	9,448.9	36.6
-Хугацаа хэтэрсэн зээл	1,383.6	1,259.3	1,540.0	280.7	22.3
-Чанаргүй зээл	2,225.6	2,058.2	2,048.7	-9.5	-0.5
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	6.0	4.3	4.0	-	-
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	9.6	7.1	5.3	-	-

Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 60.1 хувь нь иргэдийнх, 37.0 хувь нь хувийн хэвшлийн байгууллагынх эзэлж байна. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2025 оны эхний улирлын гүйцэтгэлээр 35.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 9.4 их наяд төгрөг буюу 36.6 хувиар өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 90.8 хувийг хэвийн зээл, 5.3 хувийг чанаргүй зээл, 4.0 хувийг хугацаа хэтэрсэн зээл эзэлж байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл: 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр хугацаа хэтэрсэн зээл 1,540.0 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 280.7 тэрбум төгрөг буюу 22.3 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.0 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурсан байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ: 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр чанаргүй зээлийн хэмжээ 2,048.7 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 9.5 тэрбум төгрөг буюу 0.5 хувиар буурчээ. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.3 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ 1.8 нэгж хувиар буурсан байна.

Үнэт цаас: 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр үнэт цаасны арилжаагаар 172.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 268.5 сая ширхэг үнэт цаас арилжаалжээ. Өнгөрсөн оны мөн үеэс үнэт цаасны арилжааны гүйлгээ 15.5 тэрбум төгрөгөөр, арилжаалсан үнэт цаас 290.4 сая ширхгээр тус тус буурсан байна. 2025 оны эхний улирлын гүйцэтгэлээр хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны нийт үнэлгээний дүн 12.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 1.1 их наяд төгрөг буюу 8.9 хувиар өссөн. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2025 оны 3 сард 51,068.9 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 6,717.7 нэгжээр өссөн.

Валютын ханш: Төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханш 2025 оны 3 дугаар сард 3,475.4 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 99.2 төгрөг буюу 2.9 хувиар суларсан байна. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 479.6 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.8 төгрөг буюу 2.3 хувиар мөн суларсан байна.

График 14. АНУ-ын доллар ба БНХАУ-ын юанийн ханш, төгрөгөөр /2025 оны 3 дугаар сар/




Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээний үнийн индекс:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 3 сард улсын хэмжээнд 9.1 хувь гарч, өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар өссөн байна.

Нэмж дурдахад, 2020-2022 онд тээвэр логиستيкийн хүндрэл, нийлүүлэлтийн саатлаас үүдэлтэйгээр хүнсний бүтээгдэхүүн, эрчим хүч, үйлчилгээний үнэ өссөн нь дэлхийн улс орнуудад инфляц өндөр байхад голлон нөлөөлсөн. Сүүлийн 5 сарын турш 9-10.5 хувийн хооронд хэлэлцэж байна.

График 15. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, сар бүрийн өөрчлөлт, хувиар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

5.2. Гадаад валютын албан нөөц:

Нийт албан нөөцийн хэмжээ 2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 4,996.0 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 146.9 сая ам.доллар буюу 3.0 хувиар өссөн боловч 2024 оны жилийн эцсээс 513.8 сая ам.доллар буюу 9.3 хувиар буурсан байна.

График 16. Нийт гадаад валютын албан нөөц /сая ам.доллаар/



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2025 оны 3 дугаар сард 4,996.0 сая ам.доллар болж нийт импортын 5.9 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрсэн байна.

Хүснэгт 21. Гадаад валютын албан нөөц ба импорт


/сая ам.доллар/

№	Үзүүлэлт	1 дүгээр улирлын гүйцэтгэл				
		2021	2022	2023	2024	2025
1	Нийт импорт	1,522.7	1,690.7	1,939.6	2,414.5	2,548.6
2	Гадаад валютын нийт нөөц	4,774.2	3,318.6	3,438.5	5,249.8	4,996.0
3	Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/	9.4	5.9	5.3	6.5	5.9

Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар

Худалдан авсан алт: Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2025 оны эхний 3 сарын байдлаар 2.2 тонн болж, 2024 оны мөн үеэс 1.1 тонноор буурсан байна. 2020 онд буюу Ковидын үед хамгийн өндөр худалдан авалт буюу 5.3 тонн-д хүрсэн байна.

График 17. Монгол банкны худалдан авсан алтны хэмжээ, 2013.03-2025.03 сар /тонн/



Эх сурвалж: Монголбанк

5.3. Төлбөрийн тэнцэл:

Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2025 оны эхний улирлын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 991.6 сая ам.долларын алдагдалтай, харин санхүүгийн тэнцэл 821.2 сая ам.долларын ашигтай, хөрөнгийн тэнцэл 613.9 сая ам.долларын алдагдалтай тус тус гарсан байна. Төлбөрийн тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 987.1 сая ам.доллароор суларсан байна. Төлбөрийн тэнцэл алдагдалтай гарахад урсгал тэнцэл алдагдалтай гарсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 23. Төлбөрийн тэнцэл /2023.03-2025.03 сар/

/сая ам.доллар/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын гүйцэтгэл			Өөрчлөлт
	2023	2024	2025	Дүн
I. Урсгал Тэнцэл	315.1	-537.0	-991.6	-454.6
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	613.6	-99.6	-540.5	-440.9
В. Анхдагч орлого	-434.5	-605.6	-590.2	15.4
С. Хоёрдогч орлого	136.0	168.2	139.1	-29.1
II. Хөрөнгийн тэнцэл	21.6	32.2	19.7	-12.5
III. Санхүүгийн тэнцэл	500.5	-752.3	-821.2	-68.9
IV. Алдаа болон орхигдуулга	243.3	125.6	-463.1	-588.7
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	79.7	373.2	-613.9	-987.1

Эх сурвалж: Монголбанк


ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ**6.1. Хүн ам, ажил эрхлэлт**

2025 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр улсын хэмжээнд 13.4 мянган хүүхэд шинээр төрсөн байна. 2025 оны эхний улирлын байдлаар нийт ажиллах хүчний тоо 1,459.1 мянга болж, 2024 оны жилийн эцсээс 30.3 мянгаар нэмэгдсэн байна. Ажиллах хүчнээс 1,380.1 мянган хүн нь ажилтай, 78.9 мянган иргэд нь ажилгүй хүмүүс байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилтай иргэдийн тоо 26.7 мянгаар нэмэгдэж, ажилгүй хүмүүсийн тоо 3.6 мянгаар мөн өссөн байна. 2025 оны эхний улирлын байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 62.0 хувь болж, өмнөх оноос 1.5 нэгж хувиар өссөн байна. Хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 71.0 хувь, эмэгтэйчүүдийнх 53.8 хувь байна. Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 58.7 хувь байна. Мөн 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам 893.7 мянга байна.

6.2. Ажилгүйдлийн түвшин

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 5.4 хувьтай болж, 2024 оны жилийн эцэстэй харьцуулахад 0.1 нэгж хувиар өссөн байна.

График 19. Ажилгүйдлийн түвшин, хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

